



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын код: БНА-2019/15/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер:

Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Цэрэнчимэд

Утас: 88302569

Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/79
танай _____ -ны № _____ -т
Аудитын гэрчилгээ

Г БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.БУЯНТОГТОХ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\СТА-2018\Баянговь сумын ЕБСургууль\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519143

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2018\Баянговь сумын ЕБСургууль\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сургуулийн захирал Ц.Буянтогтох-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 08-наас 2018 оны 02 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Амьдрах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвартай эрүүл, өөртөө итгэлтэй, хүнлэг, зөв монгол хүүхэд төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолол групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны нийт зардал нь 764058,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 15281,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн гүйцэтгэсэн холбогдох мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудал байхгүй, акт албан шаардлага тогтоогдоогүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд улсын төсвөөс 690851,4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 500,0 мянган төгрөг нийт 691351,4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 693035,4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 691804,9 мянган төгрөг зарцуулж, хэмнэгдсэн 1230,5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар тус байгууллага нь хуулийн 6.1-д заасан өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 13 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар хувь биелэгдсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,143,981.01	52,396,452.88
33	АВЛАГА	00.00	458,611.87
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	458,611.87
35	БАРАА МАТЕРИАЛ	42,143,981.01	51,937,841.01
351	Түүхий эд материал	1,517,700.00	1,517,700.00
35110	Тусгай зориулалттай материал	1,517,700.00	1,517,700.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	214,600.00	111,000.00
354	Хангамжийн материал	40,411,681.01	50,309,141.01
35410	Бичиг хэргийн материал	816,000.00	1,117,480.00
35420	Аж ахуйн материал	34,674,181.01	47,403,281.01
35440	Түлш, шатах тослох материал	800,000.00	190,000.00
35450	Барилгын засварын материал	360,000.00	00.00
35460	Хүнсний материал	2,610,000.00	481,880.00
35470	Бусад хангамжийн материал	1,151,500.00	1,116,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,261,203,337.16	1,240,440,945.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,261,203,337.16	1,240,440,945.57
392	Биет хөрөнгө	1,261,203,337.16	1,222,944,945.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,786,736,460.00	1,182,015,313.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-688,230,340.81	-98,527,084.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,205,629.96	170,944,169.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,202,515.98	-130,687,193.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	106,342,888.70	109,898,888.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,272,919.32	-60,101,838.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,117,904.00	33,117,904.00

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,514,912.60	-4,626,842.64
39217	Ном	19,021,143.21	20,911,629.21
393	Биет бус хөрөнгө	00.00	17,496,000.00
39301	Програм хангамж	890,000.00	890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-890,000.00	-890,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	17,496,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,303,347,318.17	1,292,837,398.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	14,420.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	14,420.00
413	Өглөг	00.00	14,420.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,303,347,318.17	1,292,822,978.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,303,347,318.17	1,292,822,978.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	301,718,873.32	319,214,873.32
51101	Өмч: - төрийн	301,718,873.32	319,214,873.32
512	Хуримтлагдсан үр дүн	81,077,884.85	38,296,494.41
51210	Өмнөх үеийн үр дүн	81,077,884.85	81,077,884.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-42,781,390.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	920,550,560.00	935,311,610.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,303,347,318.17	1,292,837,398.45

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	517,212,581.00	721,276,926.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	384,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	384,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	384,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	384,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,221,981.00	30,041,526.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	6,280,729.90
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	6,280,729.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510,990,600.00	690,851,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,199,360.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,199,360.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	2,220,886.00	5,464,540.00
133003	Хөрөнгийн	2,220,886.00	5,464,540.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,801,735.00	18,296,257.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,801,735.00	18,296,257.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	517,566,298.42	764,058,317.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,566,298.42	764,058,317.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,626,657.42	677,775,958.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,255,906.00	406,703,817.00
210101	Үндсэн цалин	252,009,863.00	406,703,817.00
210102	Нэмэгдэл	2,575,000.00	00.00
210104	Урамшуулал	26,671,043.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,970,379.00	49,122,073.13

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	30,970,379.00	49,122,073.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,710,312.00	97,971,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,428,702.00	3,709,470.00
210302	Түлш, халаалт	11,721,610.00	93,102,030.00
210303	Цэвэр, бохир ус	560,000.00	1,160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,798,640.00	8,586,740.00
210401	Бичиг хэрэг	2,102,400.00	2,296,020.00
210402	Тээвэр, шатахуун	5,366,240.00	6,290,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	00.00
2105	Нормативт зардал	33,122,840.00	48,162,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	310,000.00	00.00
210502	Хоол, хүнс	32,412,840.00	43,885,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	4,277,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,448,300.00	1,952,400.00
210604	Урсгал засвар	6,448,300.00	1,952,400.00
2107	Томилолт, зочны зардал	663,000.00	507,000.00
210702	Дотоод албан томилолт	663,000.00	507,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,215,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,215,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,442,280.42	64,769,468.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	565,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,442,280.42	64,204,468.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,939,641.00	86,282,358.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,939,641.00	85,051,857.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,276,740.00	18,296,257.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,733,000.00	23,899,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,959,457.00	28,781,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,400,444.00	13,774,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	570,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,230,501.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,230,501.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-353,717.42	-42,781,390.44

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	632,192,184.00	714,231,900.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	520,000.00	384,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	520,000.00	384,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	520,000.00	384,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	520,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	384,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,672,184.00	713,847,900.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	4,700,243.90
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	4,700,243.90

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	626,065,700.00	690,851,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,199,360.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,199,360.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	100,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,307,124.00	18,296,257.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,307,124.00	18,296,257.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	632,192,184.00	710,091,900.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	632,192,184.00	710,091,900.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,330,800.00	623,883,142.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,397,489.00	411,794,563.00
210101	Үндсэн цалин	310,823,371.00	334,039,347.00
210102	Нэмэгдэл	47,175,281.00	52,925,780.00
210104	Урамшуулал	24,398,837.00	24,829,436.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,958,481.00	41,547,851.00
210201	Тэтгэврийн даатгал	44,958,481.00	41,547,851.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,701,630.00	97,361,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,832,225.00	3,709,470.00
210302	Түлш, халаалт	29,589,405.00	92,492,030.00
210303	Цэвэр, бохир ус	1,280,000.00	1,160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,592,600.00	6,854,700.00
210401	Бичиг хэрэг	1,599,000.00	1,455,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,375,000.00	3,005,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,290,100.00	812,000.00
210404	Ном, хэвлэл	1,035,100.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,293,400.00	1,477,200.00
2105	Нормативт зардал	52,892,640.00	43,136,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	546,850.00	374,000.00
210502	Хоол, хүнс	44,508,790.00	41,769,185.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,837,000.00	993,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,252,900.00	2,650,800.00
210604	Урсгал засвар	2,252,900.00	2,650,800.00
2107	Томилолт, зочны зардал	985,000.00	503,500.00
210702	Дотоод албан томилолт	985,000.00	503,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,103,060.00	3,374,243.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,103,060.00	3,374,243.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,447,000.00	16,659,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,047,000.00	6,669,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	9,990,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,861,384.00	86,208,758.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,583,325.00	84,978,257.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,307,124.00	18,296,257.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,647,800.00	23,826,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,575,457.00	28,781,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,400,444.00	13,774,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,652,500.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	278,059.00	1,230,501.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	278,059.00	1,230,501.90

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,140,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,140,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,140,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,140,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,140,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,140,000.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	301,718,873.32	920,550,560.00	81,077,884.85	1,303,347,318.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	301,718,873.32	920,550,560.00	81,077,884.85	1,303,347,318.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	14,761,050.72	00.00	14,761,050.72
Тайлант үеийн үр дүн	17,496,000.00	00.00	-42,781,390.44	-25,285,390.44
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	38,296,494.41	1,292,822,978.45

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	691,351,400.00	691,804,899.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,351,400.00	691,804,899.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624,627,700.00	625,122,899.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,346,600.00	411,794,563.00
210101	Үндсэн цалин	334,497,400.00	334,039,347.00
210102	Нэмэгдэл	50,323,300.00	52,925,780.00
210104	Урамшуулал	25,525,900.00	24,829,436.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,383,500.00	41,547,851.00
210201	Тэтгэврийн даатгал	42,383,500.00	41,547,851.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,361,600.00	97,361,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,709,500.00	3,709,470.00
210302	Түлш, халаалт	92,492,100.00	92,492,030.00
210303	Цэвэр, бохир ус	1,160,000.00	1,160,000.00

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	7,202,700.00	7,094,700.00
210401	Бичиг хэрэг	1,455,500.00	1,455,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,005,000.00	3,005,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	812,000.00	812,000.00
210404	Ном, хэвлэл	453,000.00	345,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,477,200.00	1,477,200.00
2105	Нормативт зардал	43,137,700.00	43,136,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	374,600.00	374,000.00
210502	Хоол, хүнс	41,769,300.00	41,769,185.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	993,800.00	993,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,650,800.00	2,650,800.00
210604	Урсгал засвар	2,650,800.00	2,650,800.00
2107	Томилолт, зочны зардал	503,500.00	503,500.00
210702	Дотоод албан томилолт	503,500.00	503,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	474,000.00	474,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	474,000.00	474,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20567300.00	20559300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,577,300.00	10,569,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,990,000.00	9,990,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66723700.00	66682000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,723,700.00	66,682,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,828,000.00	23,826,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,781,700.00	28,781,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,774,800.00	13,774,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	339,200.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	691,351,400.00	691,804,899.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	690,851,400.00	691,420,899.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	690,851,400.00	691,420,899.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	384,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	384,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	52
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39
620003	Үйлчлэх ажилтан	12	12
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	466	466
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	466	466
630001	Төрийн өмчит ЕБС	466	466
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52	52

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30	30
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16
650010	Гэрээт ажилтан	06	06